



МОНГОЛ УЛСЫН НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

1997 оны 10 дугаар
сарын 23 өдөр

Дугаар А-219

Улаанбаатар
хот

Иргэдэд мэдээллээр үйлчлэх төв байгуулах тухай

НЭНУБ ба Монгол улсын Засгийн газраас хамтран хэрэгжүүлж байгаа "Хүний төлөөртой хөгжил, мэдээлэл ба холбооны технологи" төслийн хүрээнд нийслэлд "Иргэдэд мэдээллээр үйлчлэх төв" (Citizen's Information Service Center) (УУГ)-г байгуулж аж ахуйн тооцоон дээр ажиллуулсугай.

Хоёр. Төвийн захирлаар Содномдаржаа овогтой Төмөрбаатарыг 1997 оны 11 дүгээр сарын 3-наас эхлэн томилон ажиллуулсугай.

Гурав. "Иргэдэд мэдээллээр үйлчлэх төв"-ийн дүрмийг хавсралт ёсоор баталсугай.

Дөрөв. Төвийн үйл ажиллагаагаа эхлэх хөрөнгийн эх үүсвэр 3,0 сая төгрөгийг эргэж төлөгдөх нөхцөлтэйгээр зээлийн гэрээг үндэслэн түрээсийн төлбөрийн орлогоос олгохыг Өмчийн газар (н.Буянмөнх)-т зөвшөөрсүгэй.

Тав. Төвийг аж ахуйн үйл ажиллагаагаа явуулах бололцоотой байраар хангаж, харилцан аж ахуйн гэрээ байгуулж ажиллахыг Нийслэлийн Засаг даргын дэргэдэх Нийтлэг үйлчилгээний газар (н.Дашням), төвийн захирал (н.Төмөрбаатар)-д үүрэг болгосугай.



НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА
БӨГӨӨД УЛААНБААТАР
ХОТЫН ЗАХИРАГЧ

[Signature] Ж.НАРАНЦАЦРАЛТ

2007 оны 10 сарын 23 өдөр

2007 оны 10 сарын 23 өдөр



**НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ДЭРГЭДӨХ
"ИНФОКОМ ТӨВ" (УҮГ) ИЙН ДҮРЭМ**

НЭГ НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

- 1.1 Оноосон нэр Иргэдэд мэдээллээр үйлчлэх "Инфоком төв"(УҮГ)(монгол)
" Infocom " (англи)
- 1.2 "Инфоком төв"(УҮГ)-ийн орших газар нь Улаанбаатар хот, Сүхбаатарын талбай, " Иргэдэд мэдээллээр үйлчлэх төв "
- 1.3 Нийслэлийн Засаг даргын дэргэдэх "Инфоком" төв нь нийслэлийн нутаг дэвсгэр дээр иргэдэд мэдээллээр үйлчлэх Улсын Үйлдвэрийн Газар мөн
- 1.4 "Инфоком" төв нь үйл ажиллагаандаа Монгол улсын хууль болон нийслэлийн Засаг даргын захирамж,зааврыг удирдлага болгон ажиллана.
- 1.5 "Инфоком"төв нь өөрийн билэгдэл,тэмдэг хөнгөмөл хуудас,данстай байна.

**ХОЁР ЭРХЛӨХ ҮЙЛДВЭРЛЭЛ,ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЧИГЛЭЛ
ҮЙЛ АЖИЛЛАГАА**

- 2.1 Төрийн албаны мэдээллээр иргэдэд үнэ төлбөргүй үйлчилнэ.
- 2.2 Нийслэлийн иргэдэд үйлчлэх төрөлжсөн мэдээллийн сан байгуулж иргэдэд үйлчлэх мэдээллийн солилцоо,зүүчлэл,сурталчилгааг эрхэлнэ.
- 2.3 Internet-ийн сүлжээг ашиглан иргэдэд гадаад мэдээллээр үйлчлэх захиалагчийн хүсэлтээр дэлхийн мэдээллийн сүлжээнд тэдний мэдээллийг цацаж санал солилцох,найз нөхдийн уулзалтыг зүүчлэн явуулах болно
- 2.4 Мэдээллээр хангах зорилгоор тэдний сонирхсон зүйлд компьютер ашиглуулан үйлчилнэ
- 2.5 Гадаад мэдээллийн англи,орос хэлний бичгийн орчуулга хийнэ.

ГУРАВ ДҮРМИЙН САН

- 3.1 "Инфоком" товийн хөрөнгө нь төрийн өмчөөс бүрдэх бөгөөд дүрмийн сан нь 10 сая төгрөг байна.

- 3.2 Төвийн дүрмийн сан дараах хэсгүүдээс бүрдэнэ. Үүнд
- Тоног төхөөрөмж
 - Гуулах материал
 - Мөнгөн хөрөнгө

ДӨРӨВ.УДИРДЛАГА ГҮҮНИЙ ӨРХ ХЭМЖЭЭ

- 4.1 Төв нь нийслэлийн Засаг даргын шууд удирдлага дор ажиллана.
- 4.2 "Инфоком" төвийн захирлыг нийслэлийн Засаг дарга томилох бөгөөд захирал нь тус төвийн бүтэц зохион байгуулалтыг тогтооно.
- 4.3 Төвийн захирал нь дүрэмд заасан өрх хэмжээний хүрээнд төвийн өдөр тутмын үйл ажиллагааг удирдана.
- 4.4 Төвийн үйл ажиллагаатай холбогдсон бүх гэрээ хэлэлцээрийг төвийг төлөөлж захирал хийнэ.
- 4.5 Захирал нь төвийн үйл ажиллагаатай холбогдсон аливаа асуудлыг дээд удирдлагадаа санал оруулах эрхтэй.
- 4.6 Захирал нь төвийн ажилтнуудыг ажилд авах ба ажлаас чөлөөлөх эрхтэй.
- 4.7 Төвийн захирал нь дээд удирдлагаас тогтоосон хэм хэмжээний хүрээнд тус төвийн өмч хөрөнгийг захиран зарцуулах эрхтэй.

ТАВ.ТӨВИЙН ЭДГИЙН ЗАСГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА, САНХҮҮЖИЛТ БА ХЯНАЛТ

- 5.1 Төвийн санхүүгийн бүртгэлийг Монгол улсын холбогдох хууль тогтоомжийг дагуу хөтлөнө.
- 5.2 Төв нь үйл ажиллагааныхаа ашгаас нөөцийн болон бусад сангуудыг дээд удирдлагаас тогтоосон хэмжээгээр байгуулана.
- 5.3 Төвийн аж ахуйн үйл ажиллагаатай холбогдсон материал,тоног төхөөрөмжийг гухайн үеийн зах зээлийн үнээр худалдан авч байна.
- 5.4 Монгол улсын хууль тогтоомжийн дагуу элэгдэл хорогдлын шимтгэлийг байгуулана.
- 5.5 Төвийн үйл ажиллагаанд тавих байнгын хяналтыг нийслэлийн Засаг даргын даргэдэх Нийслэл үйлчилгээний газар хэрэгжүүлнэ.
- 5.6 Санхүүгийн тайланд дараахь үндсэн бүрдэл хэсгүүд заавал орсон байна.Үүнд:

- Баланс
- Орлогын тайлан
- Мөнгөн гүйлгээний тайлан
- Хүримтлагдсан ашгийн тайлан
- Нэмэлт тайлбар тодруулга

5.7 Санхүүгийн тайлангийн үнэн зөвийг төвийн захирал хариуцна

- Нөхөрлөл компанийн хуулийн 62-р зүйлд зааснаар
- Балансад тусгагдах хөрөнгө хөрөнгийн ох үүсвэрийн ангилалт 70-р зүйлд зааснаар
- Орлого үр дүнгийн тайлан 71-р зүйлд зааснаар
- Мөнгөн гүйлгээний тайлан 72-р зүйлд зааснаар
- Санхүүгийн тайлангийн нэмэлт тайлбар тодруулга 74-р зүйлд зааснаар
- Удирдлагын үйл ажиллагааны тайланг тус тус оруулна.